

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ШИЙДВЭРИЙН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА

/Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд/

2018.07.27

Улаанбаатар хот

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт “Засгийн газрын гишүүд хагас жил тутам хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлогын баримт бичгийн болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаархи тайланг холбогдох Байнгын хороонд ирүүлнэ” гэж заасан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн тайланд шинжилгээ хийж, ирүүлсэн санал дээр үндэслэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд гаргасан хууль тогтоомжийг хяналтаас хасах саналыг хавсарган хүргүүлж байна.

“Монгол Улсын Засгийн газарт хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн 2017 оны жилийн эцсийн хэрэгжилтийн танилцуулга”-ыг Улсын Их Хурлын www.parliament.mn цахим сүлжээнд байршуулсан болно.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД ТУСГАЙЛАН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

2.1. Монгол Улсын хуулийн хэрэгжилт

Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс 2017 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд хууль хэрэгжүүлэхтэй нийцүүлэн холбогдох дүрэм, журам, жагсаалтыг батлан гаргах үүрэг өгсөн Монгол Улсын 70 хуулийн 392 хэсэг, заалтыг мэдээллийн санд бүртгэж, хяналтад авсан.

2017 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 78 хуулийн 197 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс, хяналтад байгаа 26 хууль буюу 33.3 хувь, 105 хэсэг, заалт буюу 26.7 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 56 /давхардсан тоогоор/ хуулийн 287 хэсэг, заалт буюу 73.3 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Мөн 2017 оны эхний хагас жилээр хяналтаас хасах саналтай хүргүүлсэн 14 хуулийн 18 хэсэг, заалтыг хяналтаас хассан тухай мэдээг ирүүлж, өмнөх онуудад хяналтаас хасагдсан 49 хуулийн 74 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

		Хууль	Хэсэг, заалт
1	2017 оны жилийн эцсийн байдлаар хяналтанд авсан	70	392
2	Засгийн газраас ирүүлсэн Үүнээс:	78	197
-	Хяналтанд байгаа	26	105
-	Өмнөх онуудад бүрэн хэрэгжиж хяналтаас хассан	49	74

- 2017 оны хагас жилээр хяналтаас хасагдсан 14 18

3	Засгийн газраас 2017 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	56	287
---	---	----	-----

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 26 хуулийн 105 хэсэг, заалтаас 13 хуулийн 23 хэсэг, заалт буюу 21.9 хувь нь бүрэн хэрэгжсэн, 8 хуулийн 11 хэсэг, заалт буюу 10.5 хувь нь хэрэгжих шатанд, 23 хуулийн 58 хэсэг, заалт буюу 55.2 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 хуулийн 1 хэсэг, заалт буюу 1.0 хувь нь хэрэгжээгүй, 4 хуулийн 12 хэсэг, заалт буюу 11.4 хувь нь үнэлэх боломжгүй мэдээ ирүүлсэн байна.

2.2. Монгол Улсын хуулиар Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд тусгайлан үүрэг өгсөн заалтын хэрэгжилт

Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг өгсөн Монгол Улсын 12 хуулийн 106 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны жилийн эцсийн байдлаар тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний нийт 3 хуулийн 4 хэсэг, заалт буюу 3.8 хувийнх нь хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 9 хуулийн 102 заалт буюу 96.2 хувийнх нь хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн 3 хуулийн 4 хэсэг, заалтын хэрэгжилтийг авч үзвэл, давхардсан тоогоор 1 хуулийн 2 хэсэг, заалт буюу 50.0 хувь нь бүрэн хэрэгжсэн, 2 хуулийн 2 хэсэг, заалт буюу 50.0 нь хэрэгжилт хангалтгүй шатанд байна.

	Хууль /давхардсан тоогоор/		Хэсэг, заалт	
	Тоо		Тоо	Хувь
Хяналтанд авсан	12		106	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	3		4	3.8
Үүнээс:				
- бүрэн хэрэгжсэн	1		2	50.0
- хэрэгжих шатандаа	-		-	-
- хэрэгжилт хангалтгүй	2		2	50.0
- үнэлэх боломжгүй	-		-	-

2.3. Мэдээнд гарсан зөрчил

Галын аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д заасан “Боловсролын салбарт хэрэгжүүлэх гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг боловсролын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран баталж, хэрэгжүүлнэ” гэсэн хэсгийн хэрэгжилийг мэдээг 2017 оны эхний хагас жилийн байдлаар 70 хувьтай ирүүлж байсан бол 2017 оны жилийн эцсийн байдлаар 30 хувийн хэрэгжилттэй болгон, хэрэгжилтийн хувийг бууруулсан байна.

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

3.1. Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2017 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлаас Засгийн газарт үүрэг өгсөн нийт 70 тогтоолын 171 заалтыг хяналтад авсан.

2017 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 45 тогтоолын 106 заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс, хяналтад байгаа 20 тогтоолын 48 заалт буюу 28.0 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 57 /давхардсан тоогоор/ тогтоолын 123 заалт буюу 72.0 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Мөн өмнөх онуудад хяналтаас хасагдсан 17 тогтоолын 27 заалт, 2017 оны эхний хагас жилээр хяналтаас хасах саналтай хүргүүлсэн 22 тогтоолын 31 заалтыг хяналтаас хассан тухай мэдээг дахин ирүүлсэн байна.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 20 тогтоолын 48 заалтаас 11 тогтоолын 18 заалт буюу 37.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 10 тогтоолын 22 заалт буюу 45.8 хувь нь хэрэгжих шатанд, 3 тогтоолын 3 заалт буюу 6.2 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 2 тогтоолын 2 заалт буюу 4.3 хувь нь хэрэгжээгүй, 3 тогтоолын 3 заалт буюу 6.2 хувь нь үнэлэх боломжгүй мэдээ ирүүлсэн байна.

3.2. Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн Улсын Их Хурлын 12 тогтоолын 16 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналтанд авсан бөгөөд 2017 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Улсын Их Хурлын нийт 3 тогтоолын 3 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 9 тогтоолын 13 заалт буюу 81.3 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээг авч үзвэл, 1 тогтоолын 1 заалт буюу 33.3 хувь нь бүрэн хэрэгжсэн, 1 тогтоолын 1 заалт буюу 33.3 хувь нь хэрэгжих шатандаа, 1 тогтоолын 1 буюу 33.3 хувийн заалт хэрэгжээгүй байна.

ДӨРӨВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛЫН ТАЛААР

4.1. Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2017 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын Байнгын хорооноос Засгийн газарт үүрэг өгсөн нийт 100 тогтоолын 544 заалтыг хяналтанд авсан.

2017 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 46 тогтоолын 186 заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлсэнээс, хяналтанд байгаа 36 тогтоолын 124 заалт буюу 22.8 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 81 /давхардсан тоогоор/ тогтоолын 420 заалт буюу 77.2 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 36 тогтоолын 124 заалтаас 18 тогтоолын 41 заалт буюу 33 хувь нь бүрэн хэрэгжсэн, 21 тогтоолын 53 заалт буюу 42.7 хувь нь

хэрэгжих шатанд, 14 тогтоолын 23 заалт буюу 18.5 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 тогтоолын 1 заалт буюу 0.8 хувь нь хэрэгжээгүй, 5 тогтоолын 6 заалт буюу 5 хувь нь үнэлэх боломжгүй мэдээ ирүүлсэн байна. Мөн онуудад хяналтаас хасагдсан 13 тогтоолын 29 заалт, 2017 оны эхний хагас жилээр хяналтаас хасах саналтай хүргүүлсэн 22 тогтоолын 33 заалтыг хяналтаас хассан тухай мэдээг дахин ирүүлсэн байна.

4.2. Хууль зүйн байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Засгийн газарт үүрэг өгсөн Хууль зүйн байнгын хорооны 7 тогтоолын 41 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж, хяналт тавин ажиллаж байна.

2017 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Хууль зүйн байнгын хорооны 4 тогтоолын 11 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 3 тогтоолын 30 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн тогтоолын хэрэгжилтийг авч үзвэл, давхардсан тоогоор 1 тогтоолын 6 заалт буюу 54.6 хувь нь бүрэн хэрэгжсэн, 1 тогтоолын 2 заалт буюу 18.2 хувь нь хэрэгжих шатандаа, 3 тогтоолын 3 заалт буюу 27.2 хувь нь хэрэгжилт хангалтгүй байна.

Байнгын хорооны тогтоолын хэрэгжилтийн мэдээг хүснэгтээр үзүүлбэл:

	ХЗБХ-ын тогтоол /Давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
<i>Хяналтанд авсан</i>	7	41	100
<i>Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн</i>	4	11	26.8
Үүнээс:			
- <i>Бүрэн хэрэгжсэн</i>	1	6	54.6
- <i>Хэрэгжих шатанд</i>	1	2	18.2
- <i>Хэрэгжилт хангалтгүй</i>	3	3	27.2
- <i>Үнэлэх боломжгүй</i>	-	-	

4.3. Мэдээнд гарсан зөрчил

1. Хууль зүйн байнгын хорооны “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 15 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 10 дугаар тогтоолын 4.2 заалтын хэрэгжилтийн мэдээ 2017 оны эхний хагас жилийн байдлаар 70 хувийн хэрэгжилттэй байсан бол 2017 оны жилийн эцсийн байдлаар 30 хувьтай болж хэрэгжилт хангалтгүй болон буурч ирсэн.
2. Тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хяналтанд байгаа нийт тогтоолын 73.2 хувийн хэрэгжилтийн мэдээг Засгийн газраас ирүүлээгүй байгаа нь Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал,
 - Хууль зүйн байнгын хорооны “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2010 оны 19 дүгээр тогтоолын 9 заалт;

- Хууль зүйн байнгын хорооны “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны талаар авах арга хэмжээний тухай” 2012 оны 01/21 дүгээр тогтоолын 3 заалт;
- Хууль зүйн байнгын хорооны “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 2015 оны 28 дугаар тогтоолын 8 заалт;
- Хууль зүйн байнгын хорооны “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 2015 оны 29 дүгээр тогтоолын 4а, 4ж заалтууд. г.м болно.

ТАВ. БҮРЭН БИЕЛСЭН ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ЗҮЙЛ ЗААЛТЫГ ХЯНАЛТААС ХАСАХ ТУХАЙ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжсэн Монгол Улсын 1 хуулийн 2 хэсэг, заалт, Хууль зүйн байнгын хорооны 1 тогтоолын 7 заалтыг хяналтаас хасах саналыг ирүүлсэнг хавсралтаар хүргүүлэв.

ЗУРГАА. САНАЛ

1/ Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хууль тогтоомжийн хэрэгжилтийг тооцохдоо хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээнүүдийн шалтгаан нөхцөлийг тодруулж тайлбарлаагүй орхигдуулсан, хяналтанд байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн ирүүлээгүй байна.

2/ Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ирүүлэхдээ хэрэгжилт удаашралтай байгаа заалтуудын биелэлтийг сайжруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авах, хариуцсан яамд, агентлагуудад хариуцлага тооцдоггүй байх зэрэг нь хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлж байна.

3/ Хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжиж, хяналтаас хасах санал ирүүлж, холбогдох Байнгын хороонд танилцуулсан хууль тогтоомжийн заалтыг дахин ирүүлэх, мэдээллийн санг шинэчлэхгүй байх, өмнө ирүүлсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь хэмжээг бууруулан дахин ирүүлэх, шинээр хяналтанд авсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээг ирүүлэхгүй байх зэрэг дутагдалтай байна.

4/ Хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээг хагас жил тутам ирүүлэхдээ хугацааны хувьд удаашралтай, 3-4 сарын дараа ирүүлж байгаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороонд хүргүүлэхэд хэрэгжилтийн мэдээний ач холбогдолыг бууруулах, хууль тогтоомж бүрэн хэрэгжихэд сөргөөр нөлөөлж байна.

МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД
БҮРЭН ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛИЙН ЖАГСААЛТ**
/2017 оны жилийн эцсийн байдлаар/

№	Хуулийн нэр, огноо	Агуулга	Хэрэгжилт
1	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай 2015-07-08	<p>24.2.Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрлэн дохио тавьж хэрэглэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>4.2.Замын хөдөлгөөний дүрмийг Засгийн газар батална.</p>	<p>“Жолооч согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэх, зам тээврийн ослын улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо бүртгэх заавар”-ыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай хамтран боловсруулж, Хууль зүйн болон Эрүүл мэндийн сайдын 2016 оны 4 дүгээр 25-ны өдрийн А/131/138 дугаар хамтарсан тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна.</p> <p>“Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрлэн дохио тавьж хэрэглэх журам”-ыг шинэчлэн боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/62 дугаар тушаалаар батлуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p>
Нийт 1 хуулийн 2 хэсэг, заалтыг хяналтаас хасах саналтай байна.			

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ БҮРЭН ХЭРЭГЖСЭН,
ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**
/2017 оны жилийн эцсийн байдлаар/

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Агуулга	Хэрэгжилт
1	“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2016.11.16 №10	1.3.Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн төрөлжсөн асрамжийн газар байгуулах хөрөнгө, санхүүжилтийг судлан шийдвэрлэх.	<p>Хүчирхийлэл дарамтад өртөн, амь нас, эрүүл мэндэд нь аюултай нөхцөл байдал бий болсон, эрсдлийн түвшин өндөр байгаа хохирогч нарыг хамгаалах “Түр хамгаалах байр”-ыг бий болгосноор гэр бүлийн хүчирхийлэлд өртөж хохирсон иргэдийг цагдаагийн түр хамгаалах байранд байршуулж, тэдний амь нас, эрүүл мэндийг хамгаалж, эрсдэлт байдлыг сарниулан, анхан шатны тусламж үйлчилгээг тасралтгүй хэлбэрээр хүргэх ажлыг зохион байгуулж байна.</p> <p>Улсын хэмжээний түр хамгаалах байранд 2017 оны эхний 11 сард гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн нийт 96 гэр бүлийн 215 иргэнийг /насанд хүрсэн эмэгтэй 76, эмэгтэй хүүхэд 73, эрэгтэй хүүхэд 66/ хамгаалалтад авч хууль эрх зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгч, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлж, эрсдлийн үнэлгээ хийн, бүртгэл судалгаанд хамруулж байрлуулсан.</p> <p>Түр хамгаалах байрны тохижилт, үйлчилгээ, стандарт, харуул хамгаалалтын байдалд тогтмол хяналт тавин ажиллаж байна. Тухайлбал: Нийслэлийн цагдаагийн газрын Түр хамгаалах байрыг Монгол Улсын “Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 6040:2009 стандартын шаардлагын дагуу эмчийн үзлэгийн өрөө, номын сан, хоолны заал, ганцаарчилсан уулзалтын өрөө, насанд хүрсэн, насанд хүрээгүй, эрэгтэй, эмэгтэй, гэр бүлээр нь тусад нь байрлуулах зэрэг нийт 8 өрөөнд 30 үйлчлүүлэгчийг хүлээн авах хүчин чадалтайгаар засварлан тохижуулж, дуудлага хүлээн авах, цагдаагийн газар, хэлтсийн жижүүр, эмнэлэг, бусад төрийн болон төрийн бус байгууллагатай харилцах үүрэн телефоны Мобиком, Жи-мобайл, Юнител, Скайтел сүлжээний 4 төрлийн утас, “107” тусгай дугаарын утсаар хангаж байрны дотор болон гадна орчин, хоолны өрөө, ганцаарчлан уулзах уулзалтын өрөөнүүдийг хянах 14 телекамерыг суурилуулан хяналт тавин ажилласан.</p> <p>Мөн нийслэлийн Багануур дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран тус дүүргийн 1 дүгээр хороонд орон сууцны 1 давхрын 3 өрөө байрыг гэмт хэрэг, зөрчил, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн гэрч, хохирогч, насанд хүрээгүй хүнээс тайлбар мэдүүлэг авах, таньж олуулах ажиллаж байна.</p> <p>2016 оны 03 дугаар сарын 14-ний өдөр Хүний эрхийн үндэсний комисс дээр Асрамжийн газар байгуулах тухай асуудлыг авч хэлэлцэн сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийг асарч сувилах асуудал эрүүл мэндийн асуудал биш учир Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам /одоогийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам/ хариуцаж цаашид асрамжийн газрыг байгуулахаар шийдвэрлэсэн.</p>

	<p>1.4.Сэтгэцийн эмгэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эмчилгээний тусгай хэрэглэгдэхүүн, туслах хэрэгслээр хангах, эмчилгээ хийх орчин нөхцөлийг сайжруулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх.</p>	<p>Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих" үндэсний хөтөлбөр"-т "эрүүл мэндийн байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулж шаардлагатай тоног төхөөрөмж, туслах хэрэгслэлээр хангах, хүний нөөцийг чадавхжуулах" гэсэн асуудлыг тусгасан.</p> <p>Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Асрамжийн клиникт эмчлүүлж буй насанд хүрээгүй 5 хүүхдийн орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор 2 өрөөг тохижуулан хүүхдүүдийн амрах өрөө, өдөр өнжүүлэх өрөө болгон ашиглаж байна.</p> <p>Баянзүрх дүүргийн нийгмийн халамж, "Сэтгэлийн үр" төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж тэрэг, тэргэнцэр, тусгай зориулалтын ороор хангасан.</p> <p>Оюуны болон хөдөлгөөний хязгаарлалттай хүүхдүүдийг хөдөлмөр эмчилгээнд хамруулах, шарлага болон усан массаж эмчилгээг хийж байна.</p> <p>Сэтгэцийн эмгэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэвтэн эмчлүүлдэг асрамжийн 1 болон 2 дугаар клиникийн ариуйн цэврийн өрөөний хананд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бариул, түшлэгийг байршуулсан.</p> <p>Сэтгэцийн эрүүл мэндийн төвд сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай хүүхдийн 25 ортой тасаг нээн, тоног төхөөрөмжөөр ханган тохижуулсан. Мөн ЭМЯ-аас 70 сая төгрөгийн санхүүжилт гарган хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан асрамжийн тусгай өрөөг засаж тохижуулсан. Иргэний нийгмийн байгууллагууд тус өрөөнд шаардлагатай тоног төхөөрөмжүүдээр хангасан.</p>
	<p>1.5.Түр хамгаалах байрыг хуульд заасан үйлчилгээ үзүүлэх зориулалт, чиглэлийн дагуу гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалдаг стандартад нийцүүлэх.</p>	<p>Хүчирхийлэл дарамтад өртөн, амь нас, эрүүл мэндэд нь аюултай нөхцөл байдал бий болсон, эрсдлийн түвшин өндөр байгаа хохирогч нарыг хамгаалах "Түр хамгаалах байр"-ыг бий болгосноор гэр бүлийн хүчирхийлэлд өртөж хохирсон иргэдийг цагдаагийн түр хамгаалах байранд байршуулж, тэдний амь нас, эрүүл мэндийг хамгаалж, эрсдэлт байдлыг сарниулан, анхан шатны тусламж үйлчилгээг тасралтгүй хэлбэрээр хүргэх ажлыг зохион байгуулан, үйл ажиллагаан нь тогтмолжсон.</p> <p>Улсын хэмжээний түр хамгаалах байранд 2017 оны эхний 11 сард гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн нийт 96 гэр бүлийн 215 иргэнийг /насанд хүрсэн эмэгтэй 76, эмэгтэй хүүхэд 73, эрэгтэй хүүхэд 66/ хамгаалалтад авч хууль эрх зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө өгч, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлж, эрсдлийн үнэлгээ хийн, бүртгэл судалгаанд хамруулж байрлуулсан.</p> <p>Түр хамгаалах байрны тохижилт, үйлчилгээ, стандарт, харуул хамгаалалтын байдалд тогтмол хяналт тавин ажиллаж байна. Тухайлбал: Нийслэлийн цагдаагийн газрын Түр хамгаалах байрыг Монгол Улсын "Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага" MNS 6040:2009 стандартын шаардлагын дагуу эмчийн үзлэгийн өрөө, номын сан, хоолны заал, ганцаарчилсан уулзалтын өрөө, насанд хүрсэн, насанд хүрээгүй, эрэгтэй, эмэгтэй, гэр бүлээр нь тусад нь байрлуулах зэрэг нийт 8 өрөөнд 30 үйлчлүүлэгчийг хүлээн авах хүчин чадалтайгаар засварлан тохижуулж, дуудлага хүлээн авах, цагдаагийн газар, хэлтсийн жижүүр, эмнэлэг, бусад төрийн болон төрийн бус</p>

		<p>байгууллагатай харилцах үүрэн телефоны Мобиком, Жи-мобайл, Юнител, Скайтел сүлжээний 4 төрлийн утас, “107” тусгай дугаарын утсаар хангаж байрны дотор болон гадна орчин, хоолны өрөө, ганцаарчлан уулзах уулзалтын өрөөнүүдийг хянах 14 телекамерыг суурилуулан хяналт тавин ажилласан.</p> <p>Түр хамгаалан байрлуулах байр нь 2009 онд батлагдсан “Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавигдах нөхцөл, шаардлага” MNS6040 стандартын шаардлагыг мөрдөж байна. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журмыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 6 дугаар сарын 23-ний өдрийн А/116 дугаар тушаалаар баталж, олон улсын стандартад нийцүүлсэн.</p>
	<p>1.6.Ялтнаар хөдөлмөр эрхлүүлэх, хөдөлмөрийн норм, ажлын хөлсний үнэлгээг олон улсын хөдөлмөрийн байгууллагын албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенцид нийцүүлэн хөдөлмөрийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлах.</p>	<p>Шинэчлэгдэн батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 214 дүгээр зүйлийн 214.3 дахь хэсэгт “Хоригдлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын аж ахуйн ажлаас бусад ажилд хөлс, урамшуулалгүйгээр хөдөлмөрлүүлэхийг хориглоно” гэсэн заалтыг нэмж тусгасан.</p> <p>Мөн ШШГТХ шинэчлэн батлагдсантай холбогдуулан “Хоригдлын хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээг тогтоох журам”-ын боловсруулсан баталж, 2017.07.01-ний өдрөөс мөрдөн ажиллаж байна.</p>
	<p>3.2.Төрөлжсөн асрамж үйлчилгээний газрын нөхцөлийг сайжруулж, стандартын дагуу шинэчлэх.</p>	<p>Шинэчлэн батлагдсан “Ахмад настны асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 5823:2016, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5798:2016 стандартуудыг улсын хэмжээнд төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа улсын болон орон нутгийн 8 асрамжийн газар, хувийн хэвшлийн 4 асрамжийн газарт Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраар дамжуулан хэрэгжүүлэх чиглэлийг хүргүүлсэн.</p> <p>Төрөлжсөн асрамжийн газрыг магадлан итгэмжлэх ажлын хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын А/266 дугаар тушаалаар Төрөлжсөн асрамжийн газрыг магадлан итгэмжлэх орон тооны бус зөвлөлийг ХНХЯ, ХХҮЕГ, МХЕГ, ЭМЯ, БСШУЯ, Монголын ахмадын холбоо, ХБИ-ийн нэгдсэн холбооны төлөөлөл, нийгмийн ажилтан бэлтгэдэг их дээд сургуулийн төлөөлөл зэрэг нийт 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан 2017 оны 10 дугаар сарын 19-27-ний өдрүүдэд төлөвлөгөөний дагуу зохион байгууллаа.</p> <p>Төрөлжсөн асрамжийн газрын магадлан итгэмжлэлийг явуулахдаа Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, Ахмад настны асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” MNS 5823:2016 Монгол Улсын стандарт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний асрамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” Монгол улсын MNS 5823:2016 стандарт, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны А/97 дугаар тушаалаар батлагдсан “Төрөлжсөн асрамжийн газарт асруулагчийг хүлээн авах, шилжүүлэх, гаргах журам”, “Асрамжийн газрын төсвийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд</p>

			<p>хяналт тавих журам”, “Төрөлжсөн асрамжийн газрыг магадлан итгэмжлэх, ажил үйлчилгээ явуулах, эрх олгох журам, “Зардлын норматив батлах тухай”, Сангийн сайд болон Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2013 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 247/А/163 дугаар тушаалуудын хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан. Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг 8 асрамжийн газрын үнэлгээний дүнгээр стандарт хангагдаагүй байгууллага байхгүй, стандарт эхлэлийн шатандаа байгууллага байхгүй, стандарт хэрэгжилтийн шатандаа байгууллага байхгүй.</p>
		<p>4.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийг нэг бүрийн тусгай хэрэгслээр бүрэн хангаж, шинэчлэн сайжруулах зардлыг шийдвэрлэх.</p>	<p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, байгууллагуудын харуул хамгаалалтад ашиглаж байгаа тусгай, хамгаалах болон баримтжуулах хэрэгслийн судалгааг 2017 оны 03 дугаар сарын 06-ны өдөр гарган нэгтгэж, нөхцөл байдлын талаарх судалгаа хийсэн. Судалгаагаар дараах нөхцөл байдал тогтоогдсон. Үүнд: Хорих анги, байгууллагуудад нийт 1325 тусгай хэрэгслийн 466 буюу 36 хувь нь эвдрэл, гэмтэлтэй байна. Түүнчлэн нийт хорих анги, байгууллагуудын хэмжээнд хутганаас хамгаалах бээлий 28, хантааз 55 ширхэгийг ашиглаж байгаа ба гяндан, чанга, онцгой дэглэмтэй хорих ангиудад байхгүй, зарим аймгууд дахь цагдан хорих байр, Баривчлах төвд цагдаа, тахарын байгууллагаас шилжиж ирсэн. Нийт анги, байгууллагуудад 122 ширхэг энгэрийн камер ашиглаж байгаагаас 60 ширхэг буюу 49.1 хувь нь эвдрэлтэй. Хорих анги, цагдан хорих байруудад нулимс асгаруулагчаар цэнэглэсэн хийн буу 73 ширхэг байгаагаас 17 ширхэг буюу 23.3 хувь нь эвдрэлтэй, цахилгаан болон резин сумтай буу байхгүй байгааг тогтоон 679,696.000 төгрөгийн тусгай хэрэгслийг худалдан авч, хорих анги, байгууллагуудад нөхөн хангалт хийсэн.</p>
		<p>4.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийг эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамруулах зардлыг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгах.</p>	<p>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдын эрүүл мэндийг сахин хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Ерөнхий газрын харьяа 401 дүгээр хорих анги-Нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нар 2017 оны 04 дүгээр сарын 19-26-ны өдрүүдэд ШШГЕГ-ын 80 гаруй албан хаагчийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулжээ. Шинжилгээнд элэгний үйл ажиллагаа, бөөрний үйл ажиллагаа, элэгний вирусын маркер, шээсний шинжилгээ, ЭХО үзлэг хийгдсэн.</p>
<p>Нийт 1 тогтоолын 7 заалтыг хяналтаас хасах саналтай байна.</p>			